

ХХААХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн... тоот албан бичгийн 1 дүгээр хавсралт

2022 ОНЫ 06 ДУГААР САРЫН 20-НЫ БАЙДЛААР ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМАНД ИРГЭН, АЖ АХУЙ НЭГЖЭЭС ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ ГОМДЛЫГ ШИЙДВЭРЛЭСЭН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам 2022 оны 06 дугаар сарын 20-ны байдлаар иргэн, аж ахуйн нэгжээс нийт 201 өргөдлийг хүлээн авч бүртгэн хяналтад авсан байна.

Нийт өргөдөл гомдлын 97,0 хувьд хариу өгсөн байна. Шийдвэрлэх хугацаа болоогүй 6 өргөдөл байна.

Нийт ирсэн өргөдлийн 95,0 хувийг нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын чиглэлээр гаргасан хүсэлт, 0,9 хувийг салбарын ажлын талаар ирүүлсэн санал, 3,9 хувийг салбарын ажилтай холбоотой гомдол тус тус эзэлж байна.

Энэ хугацаанд тус яаманд ирсэн өргөдлийг агуулгаар нь авч үзвэл 42,2 хувийг газар тариалан эрхлэх чиглэлээр дэмжлэг хүссэн тухайлбал хөнгөлөлттэй үнээр хүнсний ногооны үр авах, мөн трактор, тоног төхөөрөмж зээлээр авахыг хүссэн өргөдөл, 39,3 хувийг Монгол Улсын хөдөлмөрийн баатар, гавьяат цол тэмдгээр шагнуулсан ахмад настан хүмүүс шагналыг дагаж олгодог тэтгэмж авахыг хүссэн өргөдөл тус тус эзэлж байна.

Бусад нь тусгай зөвшөөрөл хүссэн, сүүний урамшуулалтай холбоотой архиваас мэдээлэл авах гэх зэрэг өргөдлүүд ирүүлсэн байна.

Тайлангийн хугацаанд 8 гомдол ирснийг шийдвэрлэж хариу өгсөн.

Мөн яамны ажилтнуудаас яамны удирдлагад гаргасан 62 өргөдлийг холбогдох хууль, байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмын дагуу шийдвэрлэлээ.

.....оОо.....

ХХААХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 06 дугаар сарын 20-ний өдрийн... тоот албан бичгийн 2 дугаар хавсралт

2022 оны 06 дугаар сарын 20-ны байдлаар иргэн, аж ахуйн нэгжээс Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон албан тушаалтанд хандаж ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал

Хүснэгт 1

Д/д	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл гомдлын тоо	Шийдвэрлэлт				Шийдвэрлэлт хувь
			Шийдвэрлэж хариу өгсөн	Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн	Хугацаа болоо гүй	
	ХХААХҮЯ	201	195	-	-	6	97,0

2022 оны 06 дугаар сарын 20-ны байдлаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хандаж ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлт

Хүснэгт №2

Д/д	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл, гомдол, санал хүсэлт	Үүнээс				
			Бичгээр	Цахим хэлбэрээр	Утсаар хандсан	Биечлэн уулзсан	Бусад
	ХХААХҮЯ	201	196	-	5	-	-

Өргөдөл, гомдол, санал хүсэлтийн агуулга (хувиар)

Хүснэгт №3

Д/д	Байгууллагын нэр	Зонхилж байгаа асуудал тоо, нийт өргөдөл, гомдолд эзлэх хувь	
	ХХААХҮЯ	Нийт 201 өргөдлөөс	Хүсэлт 191 (95,0%) Санал 2 (0,95%) Гомдол 8 (3,9%)
		Нийт өргөдлөөс зонхилж байгаа асуудлууд	
		<ul style="list-style-type: none"> Салбарын чиглэлээр тусламж дэмжлэг хүссэн 85 (42,2%) Шагнал, шагналыг дагалдах мөнгөн тэтгэмж хүссэн 79 (39,3%) 	

.....оОо.....